



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.08.12 № 35-1/106
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244002797



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.08.12 № ХЭГ/1462
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ^{26/} хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд:

“7.ХЭЛЭЛЦСЭН нь:

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.08.03 № 01/6692

танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002091



САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 08. 09 № 1/245
танай _____-ны № _____-т

**Дүгнэлт, зөвшөөрөл
олгох тухай**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1} дэх хэсэгт зааснаар тус хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ



САНГИЙН САЙД Б. ЖАВХЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2024. 08. 09 № 01/1513

танай _____-ны № _____-т

Зөвшөөрөл олгох тухай

Танаас 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр ирүүлсэн 01/6624 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төсвийн тусгай шаардлагад хамрагдах төсвийн тэнцэл болох нэгдсэн төсвийн суурь тэнцлийг тооцоход үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг оруулахгүй байх зохицуулалтыг тусгасан байгаа нь цаашид төсвийн хөрөнгийн зардал огцом нэмэгдэж төсвийн сахилга бат алдагдах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоо буурч, төрийн оролцоо нэмэгдэх, Засгийн газар болон орон нутгийн төсвийн захирагч нар хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэх зорилгоор хэт их үнэт цаас гаргаж санхүүгийн зах зээлийн тэнцвэр алдагдах, улмаар макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлийг бий болгож байна.

Түүнчлэн нэгдсэн төсвийн урсгал зардлын дээд хэмжээг нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувь хүртэл нэмэгдүүлж болох заалтыг хуулийн төсөлд тусгасан байгаа нь цаашид төсвийн урсгал зардал хурдтай нэмэгдэх, уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл болон эдийн засгийн мөчлөгийг дагасан төсвийн бодлого хэрэгжих нөхцөлийг бүрдүүлснээр макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдаж, улсын зээлжих зэрэглэл буурах эрсдэл үүсэхээр байгааг анхаарна уу.

Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголын төсөлд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа тул Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалтын дагуу зөвшөөрөл олгож байна.



Л.ГАНТӨМӨР



240148

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ
2024 он



**ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН
2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулсан байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчим, нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас бий болсон үр өгөөжийг өнөө ба хойч үеийн иргэн бүрд тэнцвэртэй хуваарилах үзэл санааг хэрэгжүүлэх зорилготой Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээд байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Баялгийн сангийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.58 дахь заалтад ““Үндэсний баялгийн сангийн төсөв” гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу төрөлжсөн сан бүрд төвлөрүүлж, зарцуулах, хуримтлал үүсгэх зорилгоор тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж тус тус заасан нь Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Сүүлийн 30 жилийн хугацааны үзүүлэлтээс үзвэл Монгол Улсын нийгэм, эдийн засаг нь байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялаг, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц ашигласны үр өгөөжөөс ихээхэн хамааралтай болох нь харагддаг. Тодруулбал, эрдэс баялгийн салбарын орлого нь

2020 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн 25.7 хувийг¹, 2021 онд 28.9 хувийг², 2022 онд 35.1 хувийг, 2023 онд 33.3 хувийг тус тус бүрдүүлж байв.

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас өмнө нь тухайлсан нэг сантай холбогдох харилцааг зохицуулах зорилготой хууль тогтоомж буюу Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийг тус тус баталж байсан бол энэ оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн гурван төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгоод байна.

Иймээс Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийг боловсруулан, батлуулах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэгтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомжийн талаар;

Хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, хуримтлуулах хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд орлого төвлөрүүлж, хуримтлуулан Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

¹Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл (2020 - I-XII), 1 дэх тал.

²Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл (2021, I-XII), 2 дахь тал.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үндэсний баялгийн сангийн
2024 оны төсвийн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулсан байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчим, нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас бий болсон үр өгөөжийг өнөө ба хойч үеийн иргэн бүрд тэнцвэртэй хуваарилах үзэл санааг хэрэгжүүлэх зорилготой Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээд байна.

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас өмнө нь тухайлсан нэг сантай холбогдох харилцааг зохицуулах зорилготой хууль тогтоомж буюу Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг тус тус баталж байсан бол энэ оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн гурван төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгоод байна.

Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд орлого төвлөрүүлж, хуримтлуулан Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах, өгөөж хүртэх Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

--- оОо ---



ТАНИЛЦУУЛГА

Үндэсний баялгийн сангийн
2024 оны төсвийн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулсан байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчим, нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас бий болсон үр өгөөжийг өнөө ба хойч үеийн иргэн бүрд тэнцвэртэй хуваарилах үзэл санааг хэрэгжүүлэх зорилготой Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээд байна.

Сүүлийн 30 орчим жилийн хугацааны үзүүлэлтээс үзвэл Монгол Улсын нийгэм, эдийн засаг нь байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялаг, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц ашигласны үр өгөөжөөс ихээхэн хамааралтай болох нь харагддаг. Тодруулбал, эрдэс баялгийн салбарын орлого нь 2020 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн 25.7 хувийг¹, 2021 онд 28.9 хувийг², 2022 онд 35.1 хувийг, 2023 онд 33.3 хувийг бүрдүүлж байв.

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас өмнө нь тухайлсан нэг сантай холбогдох харилцааг зохицуулах зорилготой хууль тогтоомж буюу Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг тус тус баталж байсан бол энэ оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн гурван төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгоод байна.

Ингэснээр Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сагийн 2024 оны төсвийг боловсруулж, батлах эрх зүйн орчин бүрдээд байна.

Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд орлого төвлөрүүлж, хуримтлуулан Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах, өгөөж хүртэх Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Хуулийн төслийн зүйл тус бүрээр:



¹Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл (2020 - I-XII), 1 дэх тал.

²Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл (2021, I-XII), 2 дахь тал.

Хуулийн төсөл 2 бүлэгтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна.
Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомжийн талаар;

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ – Хуулийн зорилтыг тусгана.

2 ДУГААР ЗҮЙЛ – Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомжийн талаар

Хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

3 ДУГААР ЗҮЙЛ – Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд төвлөрүүлэх орлогын хэмжээг тусгасан.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ – Ирээдүйн өв сангийн хуримтлалын үлдэгдэл болон 2024 онд нэмж хуримтлуулах хөрөнгийн хэмжээг тусгасан.

5 ДУГААР ЗҮЙЛ – Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын хүрээнд хөрөнгө оруулалт хийх хэмжээг тусгасан.

6 ДУГААР ЗҮЙЛ – Хуулийн дагаж мөрдөх хугацааг тусгасан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, хуримтлал үүсгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж

2.1. Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомж нь Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО

3 дугаар зүйл.Үндэсний баялгийн санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхий сайд	499,529.2
	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	499,529.2
	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2-т заасан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашиг	499,529.2
	Үүнээс: Хуримтлалын санд	499,529.2
2	Сангийн сайд	788,968.7
	Татварын ерөнхий газар	788,968.7
	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.а-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгээс 20 хувь	788,968.7

	Үүнээс: Ирээдүйн өв санд	788,968.7
	Нийт орлого	1,288,497.9

4 дугаар зүйл. 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2,788,332.7 сая төгрөг байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу Ирээдүйн өв санд 2024 оны төсвийн жилд 788,968.7 сая төгрөг хуримтлуулна.

5 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 499,529.2 сая төгрөгөөр баталсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг